



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.06.15 № ХЭГ/2083  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Эрсдэлийн үнэлгээ ирүүлэх тухай

“Хуулийн төсөлд санал хүсэх тухай” Таны 2026 оны 01/3537 дугаартай албан бичигт Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Зөвшөөрлийн зөвлөлийг хуулийн төсөлд санал, дүгнэлтээ ирүүлэх талаар дурджээ.

Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 155 дугаар тогтоолоор “Зөвшөөрлийг шинээр бий болгохтой холбоотой судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ыг баталсан.

Зөвшөөрлийн тухай хууль тогтоомжид Зөвшөөрлийн зөвлөл нь дээрх аргачлалын дагуу хийсэн эрсдэлийн үнэлгээний дүнг үндэслэн зөвшөөрөл шинээр бий болгох, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг өөрчлөхөд дүгнэлт гаргахаар заасан.

Иймд ирүүлсэн албан бичигт дурдсан “ус цаг уурын үйлчилгээ” эрхлэх шинээр бий болгох зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд дээрх аргачлалын дагуу эрсдэлийн үнэлгээ хийж ирүүлнэ үү.



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР  
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН  
САЙД Ц.САНДАГ-ОЧИР ТАНАА

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Терийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.06-16 № 3Г-2/572  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хариу хүргүүлэх тухай

Танаас 2026 оны 01/3223 дугаартай албан бичгээр санал авахаар ирүүлсэн Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад материалтай танилцан дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1.Хуулийн төслийн 4.1.13, 4.1.14 дэх заалтад "Аюултай үзэгдэл", "онц аюултай үзэгдэл"-ийн тодорхойлолт нь чанарын шинжтэй бөгөөд хэмжих шалгуур тодорхой бус байна.

Түүнчлэн Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "аюулт үзэгдэл" гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах зэргийг" гэж тодорхойлсон байх тул тус хууль болон Засгийн газар эсхүл эрх бүхий байгууллагаар батлах босго үзүүлэлттэй уялдуулан "...хуульд заасан шалгуур үзүүлэлтэд хүрсэн ус цаг уурын үзэгдэл" гэж найруулах;

2.Хуулийн төслийн 4.1.15-4.1.17-д "Анхааруулах мэдээ", "Сэрэмжлүүлэх мэдээ", "Урьдчилан сэргийлэх мэдээ" гэсэн ангиллуудын ялгаа тодорхой бус байгааг анхаарах нь зүйтэй байна. Өөрөөр хэлбэл хуулийн төсөлд эрсдэлийн түвшин, өнгөний код, үзүүлэлтийн босго тусгагдаагүй байх тул Засгийн газраас батлах шалгуур үзүүлэлтээр тодорхой болгох зохицуулалт нэмэх;

3.Хуулийн төслийн 7.3-т Улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөөг 10 жилийн хугацаагаар батлахаар зохицуулсан байна. Гэвч дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд ихэвчлэн 5 жилээр батлагддаг тул 5 жил тутамд үнэлгээ хийж шинэчлэх механизм тусгах;

4.Хуулийн төслийн 10.3-т "Шинжилгээний талбай, хамгаалалтын бүс нь улсын тусгай хэрэгцээний газарт хамаарна" гэж заасан нь Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан тусгай хэрэгцээний газрын ангилалтай нийцэж байгаа эсэх тодорхойгүй байх бөгөөд хуулийг хэрэгжүүлэхэд бүх талбайг тусгай хэрэгцээнд авах шаардлага үүсэж болзошгүй эрсдэлтэй байх тул "шаардлагатай тохиолдолд улсын тусгай хэрэгцээнд авч болно" гэж найруулах;

5.Хуулийн төслийн 12.5-д бусад эх сурвалжаас гаргасан мэдээний улмаас үүсэх хохирлыг алба хариуцахгүй байхаар зохицуулсан ч хуулийн төслийн 27 дугаар зүйлээр хувийн үйлчилгээ эрхлэгчийг хуулиар зөвшөөрч, тэдгээрийн

000264002731



мэдээллийн эрх зүйн хариуцлагыг тодорхой зохицуулаагүй хийдэлтэй байх тул “Хувийн ус цаг уурын үйлчилгээ эрхлэгч нь өөрийн гаргасан мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна” гэсэн нэмэлт оруулах;

6.Хуулийн төслийн 15.7-д зөвхөн ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагаас гаргасан мэдээллийг ашиглахаар заасан нь их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын байгууллагын мэдээлэл ашиглах боломжийг хязгаарлаж болзошгүй зохицуулалт байх тул “...үндсэн эх сурвалж болгон ашиглана” гэж өөрчлөх;

7.Хуулийн төслийн 19.1.2-т тусгай хэрэгцээний мэдээний төрөл, үйлчилгээний төлбөрийн хэмжээг батлах гэж Төрийн захиргааны төв байгууллагад олгосон байна. Гэвч 26.3-т “... Үйлчилгээний төлбөрийн хэмжээг холбогдох хуулиар эрх олгосон Засгийн газрын гишүүн батална” гэж өөрөөр заасан зөрчлийг арилгах;

8.Хуулийн төслийн 23.1-д 23.1.9 хоёр удаа давтагдсан, 23.1.14-ийн дараа 23.1.15, 23.1.16 байхгүй техник найруулгын засвар хийх;

9.Хуулийн төслийн 27 дугаар зүйлээр хувийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн зохицуулалтыг заасан хэдий ч зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэл тусгагдаагүй байх тул Зөвшөөрлийн тухай хуультай уялдуулж түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэлүүдийг тодорхой тусгах;

10.Хуулийн төслийн 29 дүгээр зүйлээр хариуцлагын зохицуулалт хэт ерөнхий зохицуулсан байх тул Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг судалж:

- хамгаалалтын бүс зөрчих;
- станцын ажиллагаанд саад учруулах;
- баталгаажаагүй хэмжих хэрэгсэл ашиглах;
- худал мэдээлэл түгээх үйлдлүүдэд хариуцлага тооцох эрх зүйн үндсийг нарийвчлан боловсруулахыг анхаарах нь зүйтэй байна.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД



Н.НОМТОЙБАЯР



**МОНГОЛ УЛСЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ  
КОМИСС**

Засгийн газрын 12 дугаар байр, Барилгачдын талбай-2,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170  
Утас: (+976) 7000 0222, (+976-51) 26 29 31  
Цахим шуудан : info@nhrcm.gov.mn  
Цахим хуудас : www.nhrcm.gov.mn

2026. 06. 16 № 01/1227

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Санал хүргүүлэх тухай**

Танаас 2026 оны 01/3223 дугаар албан бичгээр ирүүлсэн Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалтай танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Хуулийн төсөлд холбогдох байгууллага, албан тушаалтан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, шийдвэр гаргахдаа ус, цаг уур, орчны хяналт шинжилгээ, уур амьсгалын өөрчлөлтийн хяналт шинжилгээний мэдээллийг заавал харгалзан үзэж, үндэслэл болгохыг үүрэгжүүлэх.

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, хүний зүй бус үйл ажиллагааны нөлөөгөөр мөнх цас хайлах, гадаргын ус ширгэх, бэлчээрийн ургамлын гарц муудах, хөрс, ус давсжих, элэгдэх, үржил шимээ алдах, элсний нүүдэл ихсэх, цөлжилт үүсэх зэрэг сөрөг үзэгдэл нэмэгдэж, хүний амьдрах орчныг доройтуулж байна. Үүний зэрэгцээ байгаль, цаг уурын аюулт үзэгдэл, гамшгийн төрөл, давтамж, үргэлжлэх хугацаа нэмэгдэн, хүн ам, нийгэм, эдийн засагт учрах хохирол өсөж, иргэдийн амьдралын чанар, тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлсөөр байна

Иймээс ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээллийг байгаль, цаг уурын аюулт үзэгдэл, гамшиг, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сөрөн тэсвэрлэх үйл ажиллагаанд оновчтой ашиглах шаардлагатай юм. Эдгээр мэдээллийг аймаг, нийслэл, орон нутгийн болон бүс, улсын түвшний нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх бодлого, шийдвэр гаргах үйл явцад ашигласнаар шийдвэрүүд илүү бодитой, үр дүнтэй болж, эрсдэлээс урьдчилан хамгаалах ач холбогдол өндөртэй болно. Гэвч одоогоор мэдээллийг ашиглах явдал хангалтгүй, зөвхөн өгөгдөл мэдээлэл авах байдлаар ашиглаж, шийдвэр гаргалтад ашиглах нь сул байгааг зарим судалгаанд дурджээ. Тухайлбал, Монгол Улс агаарын чанарын индексээр хэд дахин хэтэрсэн бохирдсон үзүүлэлттэй байна. Манай улсын нийт усны нөөц 2013 оны байдлаар 609.5 км<sup>3</sup> байсан бөгөөд 2023 онд 564.8 км<sup>3</sup> буюу 7 хувиар буурсан байна. 2020 оны байдлаар Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь буюу 120.3 сая га талбай доройтсон бөгөөд үүнээс нэн хүчтэй 4.7 хувь, хүчтэй 18.6 хувийг эзлэж байна. Энэхүү нөхцөл байдал нь хүний амьдрах орчныг доройтуулж, хүн амын дунд амьсгалын зам, уушги, гуурсан хоолой, зүрх судас, дархлааны тогтолцооны өвчлөл, хорт хавдар үүсэх зэргээр эрүүл мэндэд эрсдэл учруулах шалтгаан болж байна. Гэтэл мал аж ахуй, газар тариалан, эрүүл мэнд зэрэг салбарын уур амьсгалд мэдрэг төлөвлөлт сул хэвээр байгаа нь төр, хувийн хэвшлийн бодлого үйл ажиллагаа шинжлэх ухааны үндэслэлд

1500201194

бүрэн тулгуурлахгүй байгааг зарим судалгаанд онцолсон байна. Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс боловсруулсан “Монгол дахь эрсдэлийн мэдээлэл, эрт сэрэмжлүүлгийн тогтолцооны үнэлгээ” тайланд эрт сэрэмжлүүлгийн мэдээллийг ашиглах, гамшгийн эрсдэлийн бууруулах төлөвлөгөөнд тусгах ажиллагаа нь зөвхөн Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг төвлөрсөн бүсэд боломжийн түвшинд байгаагаас бусад бүс нутагт хязгаарлагдмал байдалтай байгааг дурдсан байна.

2.Хуулийн төсөлд төрийн байгууллагууд нэгдмэл бодлого, зорилт, чиг үүрэгт нийцүүлэн салбар хоорондын уялдаа холбоог хангаж, судалгаа, шинжилгээ, үнэлгээг нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд хамтран болон дангаар хөгжүүлж, хэрэгжүүлэх, мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо бүрдүүлэх зохицуулалтыг тусгах.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтөөс гадна хотжилт, хүн амын хэт төвлөрөл нэмэгдэж, хариуцлагагүй уул уурхай, үйлдвэрлэлийн эрчимтэй хөгжилтэй холбоотойгоор ус, агаар, хөрсний бохирдол нэмэгдэж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэд сөргөөр нөлөөлж байна. Төрийн болон төрийн бус байгууллагууд дангаар болон хамтарч өөрсдийн нөөц, чиг үүрэгтэйгээ уялдуулан байгаль орчин, ус цаг уурын өөрчлөлтийн нөхцөл байдал, хүрээлэн буй орчны бохирдол, аюулгүй байдлын талаар судалгаа, шинжилгээ хэрэгжүүлж байгаа боловч өөр өөр арга зүй, зорилготойгоор хийж байгаа нь шинжилгээний үр дүн бодитой гарах, үр дүнд суурилсан хариу арга хэмжээ авах нөхцөл бүрдэхгүй байгаа талаар Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлд тусгасан. Тухайлбал, хөрсний бохирдолтой холбоотой судалгаа, шинжилгээг БОАЖЯ, ЦУОШГ, Нийгмийн эрүүл мэндийн төв, Усны газар, Газар зүй, геодези зураг зүйн газар, Хөдөө аж ахуйн их сургуулийн эрдэмтэн багш нар зэрэг байгууллагууд ялгаатай аргазүй, зорилготойгоор гүйцэтгэж байгаа нь шинжилгээний үр дүн бодитой гарах, үр дүнд суурилсан оновчтой хариу арга хэмжээ авах нөхцөл бүрдэхгүй байна. Өөрөөр хэлбэл, хөрсний бохирдолтой холбоотой асуудлыг шинжлэн судалдаг ЦУОШГ-т төвлөрүүлж, MNS 5850:2019 стандарт дахь 23 элементийг судалж, шинжлэн тогтоох тоног төхөөрөмж, чадамжийг бүрдүүлэх шаардлагатай байгааг тус илтгэлд тусгасныг судлан үзэх нь зүйтэй байна.

3.Хуулийн төслийн 12,13 дугаар зүйлд ус цаг уур орчны урьдчилсан болон сэрэмжлүүлэг мэдээллийг иргэдэд, ялангуяа зорилтот бүлгийн иргэдэд шуурхай, хүртээмжтэй, ойлгомжтой хэлбэр (дуу, дүрс, дуу-дүрсний мэдээллийн сувгийг ашиглах)-ээр хүргэх зохицуулалтыг нарийвчлан нэмж тусгах.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг харилцаа холбооны бүх төрлийн хэрэгслээр өмчийн хэлбэр харгалзахгүйгээр шуурхай дамжуулахаар заасан боловч ахмад настан, хараа, сонсголын зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр хүргэх талаар нарийвчилсан зохицуулалтыг тусгаагүй байна. Мөн хуулийн төслийн үзэл баримтлалд “хэрэглэгчдэд хүрэх талаар нарийвчлан тусгана”, “бүх төрлийн мэдээллийн хүртээмж сайжирна”, танилцуулгад “НҮБ-ын ойрын хугацааны тэргүүлэх зорилт болох “Эрт сэрэмжлүүлгийг хүн бүрд” санаачилгын хэрэгжилтийг хангах” гэсэнтэй нийцүүлж урьдчилан сэргийлэх мэдээллийг иргэдэд шуурхай, хүртээмжтэй, ойлгомжтой хэлбэрээр хүргэх, түүнд иргэд хариу арга хэмжээ авах цаг хугацаа, боломж, чадварыг нэмэгдүүлэх талаар тодорхой журамлан тусгах нь зүйтэй байна.

Энэ нь цаг агаарын аюултай байдлыг үнэн зөв урьдчилан таамаглах, урьдчилан бэлтгэх, шуурхай, тодорхой илрүүлэх, аюултай нөхцөл байдлыг цаг алдалгүй шуурхай мэдэгдэх тогтолцоог бүрдүүлэх нь иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг эрсдэлээс хамгаалахад чухал ач холбогдолтой.

Мөн одоо үйлчилж байгаа Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Урьдчилан сэргийлэх мэдээг радио, телевиз болон мэдээллийн бусад хэрэгслээр түүнийг хүлээн авснаас хойш 15 минутын дотор тусгай дуут болон дүрсийн дохиотойгоор нийтэд үнэ төлбөргүйгээр шуурхай мэдээлнэ” гэсэн заалт хасагдсан байгаа нь мэдээллийг иргэдэд ямар хугацааны дотор хүргэх талаарх зохицуулалтгүй болж, хуулийн хийдэл үүсэхээр байгааг анхаарах.

4. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээтэй холбоотой судалгаа, шинжилгээ, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу илт тод, нээлттэй болгох, олон нийтийн оролцоог хангах, иргэдийн уур амьсгалын боловсрол, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд суурилсан байдлаар дэмжих эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх.

Ус, цаг уурын мэдээллийг найдвартай эх сурвалжаас бодитойгоор олж авах, түүнийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр үнэн зөв боловсруулан ашиглах, цаг уурын нөхцөл, өөрчлөлтөд амьдралын хэв маяг, аж ахуйн үйл ажиллагааг зохистой уялдуулах, шаардлагатай хариу арга хэмжээг тодорхойлох, мөн байгаль, цаг уурын ерөнхий төлөв байдлын талаарх мэдээлэл, мэдлэг, чадавхыг сургалт, мэдээллээр дамжуулан хэвшүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх нь өндөр ач холбогдолтой юм.

Түүнчлэн байгаль, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох, түүнээс үүдэлтэй сөрөг нөлөөллийг амжилттай даван туулах, урьдчилан сэргийлэх, орчны бохирдлыг бууруулах, хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хадгалах, ой, ус, хөрсний доройтлыг бууруулах, хяналт, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоход олон нийтийн идэвхтэй оролцоог хангах, иргэдэд түшиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх, төр-иргэний үр дүнтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх нь зайлшгүй шаардлагатай юм.

5. Хуулийн төслийн 16 дугаар зүйл /цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа/-д “иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд эрсдэл учруулахгүй байх, иргэдэд урьдчилан мэдээлэл хүргэх, тэдний оролцоо, хяналтыг тусган урьдчилан хариу арга хэмжээ авах, бэлтгэх боломжийг бүрдүүлэх, энэхүү үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг иргэдэд нөхөн төлөх, гомдол гаргах эрхийг хангах” талаар зохицуулалт нэмж тусгах.

Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны улмаас иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол, эрсдэл учрах магадлал үүсэх тул тухайн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, урьдчилан шуурхай, мэдээлэл хүргэснээр болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлтгэл хангах боломжийг бүрдүүлнэ. Түүнчлэн, энэхүү үйл ажиллагааны улмаас иргэдэд учирсан хохирлыг нөхөн барагдуулах, гомдол маргаан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг тодорхой тусгах нь зүйтэй юм.

ДАРГА



Д.СҮНЖИД



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР**

Хуульчдын гудамж 15/1, Бага тойруу, 4 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 08 55, Факс: (976-51) 26 37 39,  
Цахим шуудан: gpo@prosecutor.mn,  
Цахим хуудас: www.prosecutor.mn

2026.06.18 № 2/2457

танай 2026.06.09ны № 01/3541 -Т

**БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН  
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД  
Ц.САНДАГ-ОЧИР ТАНАА**

Таны 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 01/3541 дугаартай албан бичгээр ирүүлсэн Ус цаг уур, орчны шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон түүнийг дагалдан боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдтэй танилцаад, гаргасан саналыг хавсралтаар хүргүүлэв.


Хавсралт 2 хуудас.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН  
ОРЛОГЧ, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН  
ШАДАР ЗӨВЛӨХ **М.ЧИНБАТ**

• 15011903709

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ  
БОЛОН ДАГАЛДАН БОЛОВСРУУЛСАН БУСАД ХУУЛИЙН ТӨСӨЛД ГАРГАСАН САНАЛ**

Улсын ерөнхий прокурорын газрын 2026 оны  
06 дугаар сарын 18-ны өдрийн  
**2. /2457** дугаартай албан бичгийн хавсралт



2026.06.17

Улаанбаатар хот

| №   | Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт  | Хуулийн төсөлд гаргасан санал  |       |  | Саналын шалтгаан үндэслэл, хэрэгцээ, шаардлага  |  |
|---|---|--|-------|--|---|--|
|   |   | Өөрчлөх  | Нэмэх | 3  |   |  |
| 0   | 1   | 2  | 3     | 4  |   |  |
| <b>Нэг.Ус цаг уур, орчны шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд:</b> |   |  |       |  |   |  |
| 1   | <b>13 дугаар зүйл. Ус цаг уур, орчны мэдээ, мэдээллийг дамжуулах</b>  |  |       | 13.5.Монгол Улсад бүртгэлтэй харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь ус цаг уур, орчны шинжилгээний талаарх урьдчилан сэргийлэх мэдээг тусгай дуут болон дүрсийн дохиотойгоор нийтэд үнэ төлбөргүйгээр шуурхай мэдээлэх үүрэгтэй. | Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 7.20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Урьдчилан сэргийлэх мэдээг тусгай дуут болон дүрсийн дохиотойгоор нийтэд үнэ төлбөргүйгээр шуурхай мэдээлэх холбоо болон хэвлэл мэдээллийн байгууллагуудыг үүрэгжүүлсэн заалтыг тусгаснаар хариуцлага хүлээлгэх үндэслэл бий болго. |  |
| <b>Хоёр. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд:</b>               |   |  |       |  |   |  |
| 1   | 1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулга бүхий 7.20 дугаар зүйл нэмсүгэй:<br>“7.20 дугаар зүйл. Ус цаг уур, орчны шинжилгээний тухай | 5. Урьдчилан сэргийлэх мэдээг тусгай дуут болон дүрсийн дохиотойгоор нийтэд үнэ төлбөргүйгээр шуурхай мэдээлэх үүрэгээ хэрэгжүүлээгүй харилцаа |       |  | Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Зөрчил, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг энэ хуулиар тогтооно” гэж заасантай нийцүүлэн өөрчлөх.   |  |

|   |   |   |  |
|---|---|---|--|
|   | <p>хууль зөрчих<br/>5. Урьдчилан сэргийлэх мэдээг тусгай дуут болон дүрсийн дохиотойгоор нийтэд үнэ төлбөргүйгээр шуурхай мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн байгууллагыг хоёр мянган нэржтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>   | <p>холбоо болон хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдийг хоёр мянган нэржтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> |  |
| <p>2</p> <p>7. Хүн ам, байгаль орчинд нөлөөлөх үзэгдэл, тохиолдсон тохиолдох бүрдсэн мэдээлэх биелүүлээгүй хоёр зүүн тэнцэх төгрөгөөр торгоно</p> | <p>7. Хүн ам, байгаль орчинд нөлөөлөх аюулт үзэгдэл, гамшиг тохиолдсон буюу тохиолдох нөхцөл бүрдсэн тухай мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг хоёр зүүн нэржтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>  |   | <p>Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Зөрчил, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг энэ хуулиар тогтооно” гэж заасантай нийцүүлэн өөрчлөх.</p> |
| <p>3</p>  | <p>Ус цаг уур, орчны шинжилгээний тухай хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Монгол Улсад бүртгэлтэй иргэн, хуулийн этгээд нь зөвшөөрөл авч тусгай хэрэгцээний ус цаг уур, орчны мэдээ, мэдээлэл гаргах, хэрэглэгчид хүргэх үйлчилгээ (цаашид “хувийн ус цаг уурын үйлчилгээ” гэх)-г эрхэлж болно” гэж тусгасан байх ба дээрх үйлчилгээг зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол зөрчилд тооцох эсэхийг судалж, шийдвэрлэх.</p> |   |  |

---00---



**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР  
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,  
ХӨГЖЛИЙН САЙД**

Улаанбаатар, Чингэлтэй, 4-р хороо, Самбуугийн гудамж,  
Засгийн газрын 11-р байр  
Утас: 51263333, Факс: 51263333  
Цахим шуудан: info@med.gov.mn  
Цахим хуудас: www.med.gov.mn

2026.06.11 № 01/1705

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР  
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН  
САЙД Ц.САНДАГ-ОЧИР ТАНАА

**Санал хүргүүлэх тухай**

Танаас 2026 оны 01/3223 дугаартай “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын төсөлд санал авахаар ирүүлсэн албан бичиг, холбогдох материалтай танилцлаа.

Хуулийн төсөлд мэдээллийн чанар, үйлчилгээний хүртээмж, урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгийн үр нөлөөг үнэлэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг нэмж тусгах нь зүйтэй байна.



Эдийн засаг, хөгжлийн яам  
Удирдлага  
Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг,  
хөгжлийн сайд  
Энхбаяр Жадамба  
2026.06.11